

Судалгааны Тойм

№11 | WWW.FORUM.MN | БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ | СУДАЛГААНЫ САН | ВИДЕО

АЛЬ БОЛОХ ЭРТ ШАТНААС ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХ

ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАГДСАН БАЙДАЛ

ТОВЧ ТАЙЛБАР

Монгол Улс эрүүгийн хууль тогтоомжоо орчин үеийн эрх зүйн чиг хандлагад нийцүүлэн шинэчлэх ажлыг сүүлийн жилүүдэд хийж байгаа билээ. Энэ хүрээнд анхаарч үзэх нэг чухал эрх бол Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хууль зүйн туслалцаа авах эрх юм. Уг эрхийг хувь хүн баталгаатай эдлэх эсэх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШТХ)-иар хэрхэн зохицуулснаас ихээхэн хамаардаг. Тиймээс 2017 онд баталсан ЭХХШТХ-д аль болох эрт шатнаас хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрхэн зохицуулсан болохыг судалж, шаардлагатай санал, зөвлөмж боловсруулахыг зорилоо. Ингэхдээ

хууль зүйн туслалцаа авах эрхийн тухай ойлголт, эрт шатнаас хууль зүйн туслалцаа авах асуудал, хууль зүйн туслалцаа авагчийн эрх, заавал өмгөөлөгч оролцуулах нөхцөл, улсаас өмгөөлөгч томилох тогтолцоог хэрэгжүүлэх байгууллага, өмгөөлөгч томилох журам, томилогдсон өмгөөлөгчийн хөлс зэрэг асуудалд ач холбогдол өгч судаллаа.

Энэхүү тоймоор судалгааны гол үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг уншигчдад, ялангуяа хууль тогтоогч, иргэний нийгмийн байгууллага зэрэгт хүргэхийг зорьсон ба судалгааг бүрэн эхээр нь www.forum.mn сайтаас татаж үзнэ үү.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2017 оны ЭХХШТХ болон 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль (ЭБШТХ)-ийн зохицуулалтыг олон улсын эрх зүйн баримт бичиг, зарим орны жишиг зохицуулалттай харьцуулах байдлаар уг судалгааг хийж гүйцэтгэлээ. Ингэхдээ 2012 онд НҮБ-ын

Ерөнхий Ассамблейгаас баталсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо дахь хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэх зарчим, чиглэл”¹, 2017 онд НҮБ-ын Мансууруулах бодис ба гэмт хэрэгтэй тэмцэх газраас гаргасан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

¹ United Nations Principles and Guidelines on Access to Legal Aid in Criminal Justice Systems, General Assembly resolution 67/187, annex. Available from www.un.org/Docs/journal/asp/ws.asp?m=A/RES/67/187.

ажиллагаанд эрт үеэс хууль зүйн туслалцаа үзүүлэх загвар хууль, түүний тайлбар”², АНУ-ын Дээд шүүхийн жишиг, ХБНГУ болон Япон Улсын эрүүгийн процесс хуулийн

СУДАЛГААНЫ ДҮН

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өөрийгөө өмгөөлөх болон хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан хэдий ч ЭХХШТХ-д эдгээр эрхийг хэрэгжүүлэх механизмыг бүрэн тусгаагүйн улмаас Монгол Улсын Үндсэн хуулийн 55-р зүйлийн үзэл санаа практикт хангалттай хэрэгжихгүй байна. Одоогийн зохицуулалтаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргасан бол өмгөөлөгч оролцуулахгүйгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болохоор зохицуулсан (ЭХХШТХ§5.3.3). Мөн заавал өмгөөлөгч оролцуулахаар заасан тохиолдлыг хуульд тусгасан билээ (ЭХХШТХ§5.3.1). Цаашлаад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өмгөөлөгч авахыг хүссэн эсвэл заавал өмгөөлөгч оролцуулахаар хуульд заасан тохиолдолд өмгөөлөгчөө сонгох боломж олгох (ЭХХШТХ§5.2.1) бөгөөд тогтоосон хугацаанд өмгөөлөгчөө сонгоогүй бол шүүх, прокурор томилогдсон өмгөөлөгч оролцуулахаар зохицуулжээ (ЭХХШТХ§5.3.2). Мөн түүнчлэн төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг бие даасан хуулиар зохицуулж байна (ЭХХШТХ§5.2.5). Эдгээр зохицуулалт нь ЭХХШТХ-ийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах үндсэн агуулга юм.

зохицуулалтыг харьцуулан авч үзлээ. Мөн энэ сэдвээр өмнө нь хийгдсэн судалгаа, бусад баримт бичигт дүн шинжилгээ хийж, холбогдох этгээдээс анкетын асуулга авсан.

Гол анхаарах асуудал бол аль болох эрт үеэс хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай ЭХХШТХ-д тусгасан эсэх асуудал билээ. Аль болох эрт үеэс хууль зүйн туслалцаа авах (*Early access to legal aid*) гэдэг нь тухайн этгээд гэмт хэрэгт холбогдож сэжиглэгдсэн, баривчлагдсан, хоригдсон буюу гэмт хэрэгт шалгагдах үеэс эхлэн хууль зүйн туслалцаа авах тухай ойлголт юм. Учир нь энэ үе шатанд эрүүдэн шүүгдэх, бусад хэлбэрээр дарамтлуулах, авлига, хахууль нэхэгдэх, албадлагад өртөн гэмт хэрэг хүлээх, хууль бусаар хоригдох эрсдэл өндөртэй байдаг тул эрт шатнаас хууль зүйн туслалцаа авах нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн эрхийг хамгаалах суурь нөхцөл болдог.

Аль болох эрт үеэс хууль туслалцаа авах эрх (*right to early access to legal aid*)-ийг өмгөөлүүлэх эрх (*the right to legal advice and assistance*) болон улсаас үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх (*the right to legal aid that is funded by the State*)-ээс тусад нь авч үзэх хэрэгтэй. Учир нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний үе шатанд улсаас үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх үүссэн эсэхийг шалгахад цаг хугацаа алдах магадлалтай тул ямар нэгэн шалгуур тавилгүйгээр буюу төлбөрийн чадвартай эсэхийг үл харгалзан хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах нь дээр дурдсан эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

² United Nations Office on Drugs and Crime (2017) Model Law on Legal Aid in Criminal Justice Systems with Commentaries; https://www.unodc.org/documents/justice-and-prison-reform/LegalAid/Model_Law_on_Legal_Aid.pdf

Өнөөгийн практикт хууль зүйн туслалцаа авах эрхийг хэргийн оролцогчийн сайн дураар хэрэгжүүлэх эрх гэж үзэх хандлага ажиглагдаж байгаа бөгөөд ЭХХШТХ-д ч мөн эрт үеэс хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах асуудлыг орхигдуулсан байна.

Баривчилсны дараа “хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох” (ЭХХШТХ§31.6-1.2), сэжигтнээс мэдүүлэг авахдаа “өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах” (ЭХХШТХ§31.11-1.2) гэсэн эрхийг танилцуулахаар хуульчилсан хэдий ч энэ нь хангалтгүй юм. Учир нь ЭХХШТХ-д заасан хууль зүйн зүйн туслалцаа авах эрхтэй холбоотой бусад боломжийг танилцуулах үүрэг хүлээлгээгүй байна. Тиймээс өмгөөлөгчөөсөө татгалзах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал өмгөөлөгчтэй байх хуульд заасан тохиолдлууд, төлбөрийн чадваргүй бол үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах боломж, өмгөөлөгчөө өөрөө сонгож чадаагүй бол төрөөс өмгөөлөгч томилуулах, өмгөөлөгчийн үйл ажиллагаа хуулиар хамгаалагдсан байх зэрэг мэдээллийг өгөх шаардлагыг хуульд тусгах нь зүйтэй.

Түүнчлэн баривчлагдсан этгээд хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэхийг хүсвэл мөрдөгч, прокурор, шүүгч хэдий хугацаанд, ямар арга хэмжээ авах, өмгөөлөгчтэй хэрхэн холбож өгөх асуудлыг хуулиар зохицуулаагүй. Тухайлбал Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж буй мөрдөгч, прокурор, шүүгч улсын өмгөөлөгчтэй хэрхэн холбогдох, гэмт хэрэгт холбогдсон этгээдийг төлбөрийн чадваргүй болохыг хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны аль үе шатнаас тогтоох талаар мөрдөгчийн хэрэгжүүлэх ажиллагааг тодорхой зохицуулаагүй.

Мөн өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах эрхийг сануулаагүйгээс үүдэх үр дагаврыг зохицуулаагүй байна. Үүний зэрэгцээ хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх хүсэлт гаргасан ч хязгаарласан, татгалзсан, хойшлуулж удаашруулсан тохиолдолд эрхээ сэргээхийг шаардах, нотлох баримтаас хасуулах зэрэг зохих хамгаалалтыг хуульчлаагүй байна. Өмгөөлөгч “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй ганцаарчлан уулзах, түүнээс мэдүүлэг авахад байлцах, асуулт тавих” эрхтэй (ЭХХШТХ§5.1-2.1) гэж хуульчилсан ч өмгөөлөгчид мэдэгдэх үүргийг хуульд тусгаагүй.

ЭХХШТХ-д томилогдсон өмгөөлөгч оролцуулахаар заасан ч томилогдсон өмгөөлөгчийг хэрхэн яаж оролцуулахыг нарийвчлан зохицуулаагүйн зэрэгцээ томилогдсон өмгөөлөгчөөр хэн оролцох нь ч тодорхойгүй. Энэ нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хамгийн гол зохицуулалт байтал маш тодорхойгүй зохицуулалттай байна.

Түүнчлэн төлбөрийн чадваргүй болохыг тодорхойлох арга хэт явцуу учир төлбөрийн чадваргүйгээсээ болоод хууль зүйн туслалцаа эрт үеэс авч чадахгүй байх нь түгээмэл тохиолддог. Өөрөөр хэлбэл, төлбөрийн чадваргүй болохыг тодорхойлох журам, стандарт нь нийгмийн халамж олгох өнөөгийн тогтолцоонд суурилсан. Энэ нь гэр бүлийн орлогод суурилдаг бөгөөд үүнийг хувь хүний төлбөрийн чадамжийг тодорхойлоход ашиглах нь өрөөсгөл юм.

ЗӨВЛӨМЖ

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид хууль зүйн туслалцаа авах эрхийг сануулахдаа хуульд заасан боломжуудыг бүрэн агуулсан байх шаардлагыг хуульд тусгах;

Хууль зүйн туслалцаа авах хүсэлтэй байгаа тохиолдолд нэн тэргүүнд эрхийг нь эдлүүлэх боломжийг хуульд тусгах;

ЭХХШТХ-ийн томилогдсон өмгөөлөгчтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгох, тухайлбал томилогдсон өмгөөлөгч оролцуулах асуудлыг ямар субъект хэрэгжүүлэх, өмгөөлөгчийг хэрхэн томилох, томилогдсон өмгөөлөгчийн төлбөрийг хэрхэн шийдэхийг тодорхой зохицуулах;

Өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргаснаас бусад тохиолдолд өмгөөлөгч

сонгон авах, улсын өмгөөлөгч оролцох хүртэл томилогдсон өмгөөлөгч оролцдог байхаар зохицуулах;

Төлбөрийн чадвартай эсэхийг тодорхойлохдоо амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүн байх гэсэн шалгуур тавьж байгаа нь хэт явцуу шалгуур тул гэмт хэрэгт шалгагдаж байгаа тухайн цаг үед хэрэгт холбогдсон этгээдийн өмчлөл, эзэмшилд байгаа, хурдан хугацаанд санхүүгийн эргэлтэд оруулах боломжтой өмч хөрөнгө, бэлэн мөнгийг тооцох, ингэхдээ тухайн асуудлаар өмгөөлөгчийн төлбөрийг зах зээлд тогтсон доод ханшаар тооцоход төлөх боломжтой эсэхийг харгалзан төлбөрийн чадвартай эсэхийг тодорхойлох.

СУДАЛГААНЫ БАГИЙН АХЛАГЧ:
Н.Норовсамбуу, LL.M

СУДЛААЧИД:
М.Цэнд-Очир, LL.M
Ж.Содномдаржаа, Өмгөөлөгч

СУДАЛГААНЫ ТОЙМ БОЛОВСРУУЛСАН:
Н.Норовсамбуу, LL.M

САНАЛ, ШҮҮМЖ ӨГСӨН:
ННФ-ын Хуулийн хөтөлбөрийн менежер, Б.Хишигсайхан



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: (976) 76113207

<http://www.forum.mn>
<http://www.twitter.com/ForumOS>

<http://facebook/OpenSocietyForum>
http://www.instagram.com/open_society_forum